



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019-06-26 № 1a/2940

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЪЯА  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,  
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ЗАХИРАЛ НАРТ**

Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 47 дугаартай тушаалаар батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай албан даалгаврыг хүргүүлж байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг үүгээр мэдэгдье.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

083279



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.06.14 № 1/1054

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЯАМД, АЙМАГ, НИЙСЛЭЛ,  
ДҮҮРГҮҮДИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ  
ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ,  
ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ  
БУС САЛБАР ЗӨВЛӨЛД

**Албан даалгавар хүргүүлэх тухай**

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 22 дугаар тушаалаар байгуулагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих зөвлөл”-ийн 2019 оны анхдугаар хуралдааныг энэ оны 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны бус салбар зөвлөлөөс хийгдэж бүтээж ажлын тайланг хэлэлцсэн.


Тус хуралдааны үр дүнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын “Хариуцлагатай хэрэглээ-хэрэглэгчийн эрх”-ийн жилийн зорилттой уялдуулан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайд 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 47 дугаартай албан даалгавар гаргасаныг үүгээр хүргүүлж байна.

Албан даалгаварт тусгагдсан арга хэмжээг харьяалах салбар, орон нутагтаа зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх тайлан, мэдээг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр дотор ирүүлнэ үү.

Албан даалгаврыг хавсаргав.

ДАРГА

Б.ЛХАГВА





# МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 дугаар  
сарын 28 -ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хот

Албан даалгавар өгөх тухай

"Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих зөвлөл"-ийн 2019 оны анхдугаар хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас "Хариуцлагатай хэрэглээ-хэрэглэгчийн эрх"-ийн жил болгон зарласантай уялдуулан яам, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны бус салбар зөвлөлийн тайланг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын оршин суугчдад хотын соёлыг төлөвшүүлэх зорилготой ажлуудыг тогтмол зохион байгуулах; Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй амьдралд сөрөг нөлөөтэй ил задгай, аюултай хог хаягдал, жорлонг шийдвэрлэх бодит ажил хийх; Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг 2019 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлуулж хэрэгжүүлж эхлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэл, дүүргийн төр захиргааны байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.

2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд хөрөнгө зарцуулах; Хэрэглэгчдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хэрэглээний соёл боловсрол олгох зорилготой соён гэгээрүүлэх иргэдэд чиглэсэн ажлыг тогтмол зохион байгуулах болон ААН, иргэдийг хэрэглэгчийн эрхийн асуудлаар мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр тогтмол хангаж ажиллахыг Салбарын яам, аймгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус салбар зөвлөлүүдэд даалгасугай.

3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг холбогдох газруудаас авч нэгтгэн, дүгнэлт боловсруулж ирүүлэхийг ШӨХТГ –т (Б.Лхагва) даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын зөвлөх С.Янжинсүрэнд үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар сайд

Ө.ЭНХТҮВШИН